						- Баруун-Урт суманд хамрагдалт 2. МСЭМХ, Глобал сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд сүрьеэгийн хавьтлын илрүүлэг зохион байгуулах хамтран ажиллах гэрээний дагуу Баруун-Урт, Асгат, Халзан, Мөнххаан, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдад ЭМГ, АНЭ хамтарсан баг ажиллаж 1467/хавьтал-728/ иргэнийг үзлэгт хамруулснаас 8 шинэ тохиолдлыг илрүүлж ажилласан байна. 8. 7 сая 3. МСЭМХ, Глобал сангийн дэмжлэгтэй "СҮРЬЕЭГҮЙ ЭРДЭНЭЦАГААН" зорилтот хөтөлбөр хэрэгжиж зорилтот бүлгийн 424 иргэнийг хамруулснаас 204 иргэнд цээжний рентген зураг өөрчлөлттэй гарсан 4 тохиолдол батлагдаж, эмчилгээнд 100% хамрагдсан. 4. Эрүүл Сүхбаатарчууд төслийн хүрээнд 1500 иргэнийг ХДХВ /ДОХ/ БЗДХ урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 9 шинэ тохиолдол илрүүлж эмчилсэн 5. Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх Аймгийн засаг даргын 2017 оны А/477 дугаар захирамж “Элэг бүтэн Сүхбаатар” аймгийн дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж гепатитын В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд 3500 хүн хамруулсан үүнээс эрүүл мэндийн даатгалгүй-2295, даатгалтай-1205. С вирус эерэг-206, В вирус эерэг 462 илэрсэн.С вирус тоолох шинжилгээнд-108, В вирус тоолох шинжилгээнд-232 хамрагдсан. С вирусийн эмчилгээнд-43, В вирусийн эмчилгээнд-85 иргэн хамруулсан. В вирусийн урьдчилан сэргийлэх вакцинд 1358 иргэнд хийгдээд байна	
--	--	--	--	--	--	---	--

6.1.2	Арга хэмжээ 2: “Элэг бүтэн” хөтөлбөрийг хэрэгжүүлж элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж илэрсэн өвчлөлийг эмчилгээнд бүрэн хамруулах, В эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулна.	ЭМД	Элэгний эрт илрүүлгийн хувь	80%	85%	Файр тбб, Ротари клуб, Японы Сагагын их сургуультай хамтран Гепатитгүй Монголчууд төслийг Сүхбаатар аймагт 2021-2022 оны хооронд хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төслийн хүрээнд нийт 3458 иргэдэд В,С вирус илрүүлэх шинжилгээ хийгдсэнээс 452/13% элэгний В вирус эерэг, 201/5,8% элэгний С вирус эерэг илрээд байна. Төслийн хүрээнд 3-р шатлалын эмч нарын үзлэгийн баг 13 суманд үзлэг хийж Дотрын эмчийн үзлэг-1795, Хавдрын эмчийн үзлэг- 85, дотрын эхо- 2882, Фиброскан-1342 иргэдийг үзлэгт хамруулж элэгний хавдрын сэжигтэй 43 тохиолдлыг илрүүлж ХСҮТ-д шилжүүлж хяналтад авсан. Нийт В,С ирлүүлэг шинжилгээнд 3500 хамруулсан үүнээс эрүүл мэндийн даатгалгүй-2295, даатгалтай-1205. В вирус тоолох шинжилгээнд-232 хамрагдсан. В вирусийн урьдчилан сэргийлэх вакцинд 1358 иргэнд хийгдээд байна. Төслөөр илэрсэн 201 С вирустэй иргэдээс С вирусийн идэвхжил тоолуулаагүй-88, тоолуулсан-113 үүнээс идэвхжилтэй -38, идэвхжилгүй- 75. Төсөл эхэлснээс хойш АНЭмнэлэгт дотрын 7 эмч өөрт хуваарилагдсан сумдын иргэдийг хяналтад авч 42 хүнийг эмчилгээнд хамруулаад байна. 12 сарын байдлаар эмчилгээ дууссан-47, эмчлэгдэж байгаа-15, нас барсан-3 байна.	90
6.1.3	Арга хэмжээ 3: Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх цогц үзлэг, хавьтлын үзлэг, сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Төсөл хөтөл бөр	Сүрьеэгийн өвчлөлийн түвшинд 10 000 хүнд Сорьц тээвэрлэсэн тоо Илэрсэн хувь	7.9 272 12	10.5 500 20	2022 оны байдлаар нийт 5370 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн 10000 хүн амд 824.0 тохиолдол ногдож байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 9074 тохиолдлоор буурсан байна. Сүрьеэ өвчний 61 тохиолдол бүртгэгдсэн байна. 10000 хүн амд 9.2 энэ нь өмнөх оны мөн үеэс 10/1.3 промилиор өссөн байна. Глобал сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд сүрьеэгийн хавьтлын илрүүлэг зохион байгуулах хамтран ажиллах гэрээний дагуу Баруун-Урт, Асгат, Халзан, Мөнххаан, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдад ЭМГ, АНЭ хамтарсан баг	100

						ажиллаж 1467/хавьтал-728/ иргэнийг үзлэгт хамруулснаас 8 шинэ тохиолдлыг илрүүлж ажилласан байна. Мөн Глобал сангийн дэмжлэгтэй Эрдэнэцагаан суманд зорилтот бүлэгт чиглэсэн Сүрьеэгүй сум төсөл хэрэгжиж байна. Сумдын засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Асгат, Түмэнцогт сумдын Сүрьеэг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 276 иргэнд идэвхтэй хяналт, рентгенд- 1193 иргэдийг хамруулан, сорьцын шинжилгээнд 35 илгээснээс шинэ 3 батлагдаж эмчилгээнд хамруулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 13 нэгжээс сорьцыг тогтмол тээвэрлэж байгаа бөгөөд сумаас аймаг руу- 299 хүний 598 сорьц, аймгаас ХӨСҮТ-рүү - 28 хүний 56 сорьц тээвэрлэсэн. 10 дугаар сарын 23-ны байдлаар 712 хүний 1428 сорьцод түрхцийн шинжилгээ хийгдсэн GEN-EXPERT- 477 хийгдсэн байна. Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг -ээс сүрьеэгийн диспансерын нийт 12 ажилчид, нийгэмлэгийн сайн дурын идэвхтэн 10 хүн нийт 22 хүнд 300ш нэг удаагийн маск, 100 ш бээлий олгосон. Монголын улаан загалмайн нийгэмлэг, Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг хамтран глобал сангийн дэмжлэгтэйгээр сүрьеэгийн эмчилгээтэй байгаа үйлчлүүлэгчдэд сар бүр 6 хүн сонгон 122500 төгрөгийн хүнсний тусламжийг сар бүр олгож байна.	
6.1.4	Арга хэмжээ 4: Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа,	Улсын төсөв	Хачигт халдвар тохиолдол 10000 хүн амд	0	0	ЗӨСҮТ-өөс ЭМГ, АНЭ, ӨЭМТ, МЭ, МХГ, ОБГ, ЦГ зэрэг 8 байгууллагын 28 ажилтан албан хаагчдад Тарваган тахал, Галзуу, Боом, Хачигт халдвар зэрэг	90

	нотолгоонд тулгуурлан зохион байгуулж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах					зоонозын халдварт өвчнүүдийн үед ажиллах, хариу арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар танхимын сургалтыг зохион байгуулсан. Дээрх сэдвээр анхан шатны ЭМБ-ын 55 эмч эмнэлгийн мэргэжилтэнд цахим сургалтыг зохион байгуулан ажилласан. Тарваган тахал, Галзуу, Боом, Хачигт халдвар зэрэг зоонозын халдварт өвчнүүдээс сэргийлэх чиглэлээр иргэд олон нийт рүү чиглэсэн 5 төрлийн мэдээллийг эрүүл мэндийн газрын цахим хуудсанд байршуулж 500 хандалт авсан. Орон нутгийн телевизээр 2 удаа тарваган тахал болон хачигт халдвараар мэдээлэл өгч ажилласан. Зоонозын шалтгаант халдварт өвчний бруцеллёз өвчний 2 тохиолдол бүртгэгдсэнд тандалт судалгааг зохион байгуулж ХӨСҮТ, ЭМХТ-рүү мэдээлэн ажилласан. Австралийн улаан загалмайн дэмжлэгтэйгээр Монголын улаан загалмайн нийгэмлэгээс зохион байгуулж буй Олон нийтийн оролцоонд тулгуурласан Зоонозын халдварт өвчнийг илрүүлэх, тандах, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөрт Асгат, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Уулбаян, Мөнххаан, Дарьганга сумдыг хамруулахаар ажиллаж байна. Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан зохион байгуулж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах талаар Хэнтий аймгийн зоонозын төвтэй туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан. Үүний үр дүнд ЭМЯ, ЗӨСҮТ-рүү Сүхбаатар аймагт Зоонозын төв байгуулах саналыг хүргүүлэн ажиллаж байна.	
--	---	--	--	--	--	---	--

6.1.5	Арга хэмжээ 5: Эрсдэлт бүлгийн хүн амыг БЗДХ-ыг илрүүлэх идэвхтэй илрүүлгийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн БЗДХ-ын тохиолдлын тоо Үүнээс эмчилгээнд хамрагдсан хүний тоо	624/16 16	2500/30 0 30	Бэлгийн замаар дамжих халдвар нь нийт халдвар өвчний 221 буюу 4,1%-ийг эзэлж байна. 10000 хүн амд 33,9 энэ нь өмнөх оны мөн үеэс 4,7 промилиор буурсан байна. 2022 онд Баяндэлгэр, Мөнххаан, Түвшинширээ, Эрдэнэцагаан сумдад бэлгийн замын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх шинжилгээнд 924 эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг хамруулж, хуучин -192, шинэ-9 тэмбүү өвчин илрүүлж хавьтлыг 100% шинжилгээнд хамруулсан. - Эрсдэлт бүлгийн хүн амыг БЗДХ-ыг илрүүлэх идэвхтэй илрүүлгийн үзлэгт хамруулах ажлыг Сумдын засаг даргатай байгуулсан гэрээний дагуу зохион байгуулж Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Асгат, Түмэнцогт сумдын 15-49 насны 13990 иргэд, зорилтот бүлгийн 5591 хүн амыг ХДХВ /ДОХ/ БЗДХ урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулснаас хуучин-280, шинэ - 13 тэмбүү өвчнийг илрүүлж хавьтлын эмчилгээг 100 хувь хийлгэсэн байна. Сүрьеэг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 276 иргэнд идэвхтэй хяналт, рентгенд- 1193 иргэдийг хамруулан, сорьцын шинжилгээнд 35 илгээснээс шинэ 3 батлагдаж эмчилгээнд хамруулан ажиллаж байна.	90
Зорилт 2: Уур амьсгалын өөрчлөлт, орчин болон хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.							
6.2.1	Арга хэмжээ 1: Агаарын бохирдол, тоосжил, хөрсний бохирдол, хөрс ургамлаас шалтгаалсан харшлын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор “Харшлын эсрэг хөтөлбөр” -ийг хэрэгжүүлж,	ЭМД	Бохирдуулах бодисын бууралт РМ 2.5 тоосонцор	138	120	Хөрс ургамлаас шалтгаалсан харшлын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор “Харшлын эсрэг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж харшлын хатгах сорил аймагтаа шинээр тавьж, сийвэн эмчилгээг эхлүүлсэн. Сорил -114 Эмчилгээ -39 Эмчилгээний үр дүн	90

	хүн амын эрүүл мэндийг хамгаална.					Иргэдэд харшлаас сэргийлэх дадал хэвшил олгох зорилгоор цахим хэлбэрээр 6-8 сарын хооронд зөвлөл мэдээллийг байршуулж ажилласан - Агаарын бохирдол, Хөрсний бохирдлын чиглэлээр ЭМГ-ын цахим хуудсанд 6 удаагийн мэдээлэл байршуулж, нээлттэй өдөрлөгөөр 3 төрлийн 100 ширхэг тараах материал тарааж ажилласан	
6.2.2	Арга хэмжээ 2: Ундны ус, ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөө хэрэгжүүлэх, стандартын дагуу жорлон, муу усны нүх барьж, ашиглах, нийтийн эзэмшлийн зам, талбайг эрүүл, цэвэр байлгах хөдөлгөөн өрнүүлж ажиллах.	Орон нутгийн төсөв	Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	50	70	- МХГ, БОАЖГ, ЭМГ-ууд хамтран иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажил, мэдээллийг олон нийтийн хэрэгслээр тогтмол хүргэн ажиллаж байна - 2021 оны А/88 тоот тушаалын дагуу Боловсролын салбарын ариун цэврийн байгууламжийн шинэчлэх цогц үйл ажиллагаа явагдаж 3 сургуулийн 5 байгууламж (Халзан ,Наран, Эрдэнэцагаан) шинэчлэгдэж цаашид 2024 он хүртэл хэрэгжүүлэхээр зураг төслийг хүргүүлэн ажиллаж байна. - Аймгийн ЗДТГ, БОАЖГ-тай хамтран Хаягдал усыг дахин ашиглах, дэвшилтэт технологи, нүхэн жорлонг хэрхэн энгийн хялбар аргаар цэвэрхэн, хямд өртгөөр эко болон био ариун цэврийн байгууламжтай болох байгальд ээлтэй ариун цэврийн байгууламж, зэргийн талаар МХГ, Баруун-Урт сумын ЗДТГ, Дөрвөлж ОНӨК, Мах боловсруулах үйлдвэр, ШТС, авто угаалгын газар зэрэг 28 ААН-ын 49 ажилтанд ШУТИС-ын багш нар сургалт зохион байгууллаа. - Хүн ам унд ахуйдаа хэрэглэдэг ус нь стандартын шаардлага хангаж буй эсэхийг тодорхойлох зорилгоор сумдын эх үүсвэрийн-16 цэгт хяналт шинжилгээ хийсэн. Хяналт шинжилгээгээр 32 дээжид, 122 үзүүлэлтээр	70

						хими, хор судлалын лабораторид, 96 үзүүлэлтээр нян судлалын шинжилгээнд тус тус хамруулав. Нийт дээжийн 75 хувьд магни агууламж стандартад зааснаас 32 хувиар их байна. - <u>Хүрсэн үр дүн:</u> Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018 стандартын шаардлагыг хангахгүй гарсан үзүүлэлтийг давтан шинжилгээ авч нянгийн бохирдлыг арилгуулан ажилласан	
6.2.3	Арга хэмжээ 3: Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн мобайл технологийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалт, зарим нэмэлт төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.	Төсөл хөтөл бөр	Тоног төхөөрөмжийн хэрэглээний хувь сургалтын тоо	70.0 1	85.0 1	ДЭМБ хөрөнгө оруулалтаар 2 сум, Аймгийн хөрөнгө оруулалтаар 7 сум, 3 өрх, сумдын хөрөнгө оруулалтаар 3 сумын ЭМТ-үүд мобайл технологиор 100 хувь хангагдсан. ДЭМБ-ын санхүүжилтээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх сургалтын хүрээнд анхан шатны 15 эрүүл мэндийн байгууллагуудын 45 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд мобайл технологийг ашиглалтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан.	100
6.2.4	Арга хэмжээ 4: Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан хийх	Улсын төсөл	Телевиз Сонин Сайт Үүрэн телефоны оператор	108 15 - 0		Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тогтмол мэдээ мэдээлэл өгч ажилласан. Телевиз 25 мэдээ 31 шторк 744 удаагийн давталттай, Сонин 20 удаагийн дугаарт эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл, Вэб сайт, фэйж хуудсанд тогтмол мэдээ мэдээлэл байршуулж 11 сарын байдлаар 24838 хүн хандсан байна.	100

Зорилго 7: “МОНГОЛ УЛСЫН АЛСЫН ХАРАА -2050 МУЗГ-ЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР” Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийг нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглах							
Зорилт 1: “Эрүүл мэндийн статистикийн мэдээ мэдээллийг нэгтгэх тайлагнах, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх,эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд хүргэх, мэдээллийн сан бүрдүүлж баяжуулалт хийх.”							
7.1.1	Арга хэмжээ 1: “Эрүүл мэндийн тухай” хууль “Эрүүл мэндийн сайдын ” 2019 оны 12 сарын 30 - ны А/611 дугаар тушаалын хэрэгжүүлэх.		Эрүүл мэндийн анхан шатны бүртгэл маягтыг 100 хувь хөтлөх	80 хувь	100 хувь	Эрүүл мэндийн сайдын ”2019 оны 12 сарын 30-ны А/611 дугаар тушаалыг хэрэгжүүлэн анхан шатны бүртгэл мэдээ, тайлан, маягтыг хөтөлж байна.	100
7.1.2	Арга хэмжээ 2: Эрүүл мэндийн салбарын статистик мэдээллийн цахим санг үүсгэх, иргэдэд эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний мэдээллийг цахимаар шуурхай хүлээн авах боломж нөхцөлийг бүрдүүлэх.		Эрүүл мэндийн яамнаас зөвшөөрөгдсөн,эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэгдэж буй hinfov3. E-health программ хангамжуудыг орон нутагт үйл ажиллагаандаа ашиглах	95 хувь	100 хувь	Салбарын хэмжээнд hinfov3. E-health –АНЭ, E-hospital программ хангамжуудыг орон нутагт үйл ажиллагаандаа ашиглаж, статистик мэдээллийн цахим санг үүсгэж, иргэдэд эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний мэдээллийг цахимаар шуурхай хүлээн авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.	100
7.1.3	Арга хэмжээ 3: Телемедициныг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд өргөжүүлэн ашиглах		Аймгийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн төвд телемедицин зайн сургалтыг тогтмол хийх нөхцөл бололцоог сайжруулах арга зүйн зөвлөгөө өгч ажиллах	80 хувь	90 хувь	ЭМЯ, ЭМХҮТ, 12 сум 3 өрх АНЭмнэлэг, Эрүүл мэндийн газар zoom. google meet ашиглан телемедицин ашиглаж хэвшсэн. АНЭмнэлгийн 103 яралтай тусламжийн тасагт zoom meeting ашиглан анхан шатны эрүүл мэндийн төвүүдтэй зайн оношилгоо, зөвлөгөө хийж хэвшсэн.	100
7.1.4	Арга хэмжээ 4: Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, салбарын гүйцэтгэлийн болон тухайн жилийн төлөвлөгөө болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж		-Тайлангийн төрөл -Тайлангийн чанар /хувиар/	Эхний хагас жилийн хугацаа ат тайлан холбогдох газрууд	Жилийн эцсийн тайлан мэдээ хугацаандаа холбогдох	Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, салбарын гүйцэтгэлийн болон тухайн жилийн төлөвлөгөө болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. 2022 оны тайлан болон сар бүрийн тайланг Эрүүл мэндийн яам, Засаг даргын тамгын газарт цахим системээр хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Мөн 12 сумын Эрүүл мэндийн төвийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө	90

[illegible]

8.2.1	Арга хэмжээ 1: Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нөхөрлөл хэлбэрт шилжүүлэх	0	Нөхөрлөл байгуулсан байгууллагын тоо	0	3	Аймгийн Засаг даргын 2022 оны А/386 дугаар захирамжийн дагуу шинээр үүсгэн байгуулагдсан Энхлэн Ачтан, Энэрэлт Ачтан гэсэн 2 нөхөрлөлтэй гэрээ байгуулан ажиллаж байна.	90
Зорилго 9: МУЗГ-ЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2.1.12.АЙМАГ, СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, ЭМНЭЛГҮҮДИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛАН СТАНДАРТ, ЧАНАРЫН ШААРДЛАГА ХАНГАСАН ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
Зорилт 1: Эрүүл мэндийн салбарын салбарын барилга байгууламжийн чанарыг сайжруулах							
1	2	3	4	5	6	7	8
9.1.1	Арга хэмжээ 1: Мөнххаан суманд шинээр баригдаж буй 17 ортой эрүүл мэндийн төвийн шинэ барилгын угсралтын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад хүлээн авах	1,5 тэр бум төгрөг	Гүйцэтгэлийн хувь	0	Бүрэн ашигла лтад орсон байна.	Улсын төсвийн 2,0 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мөнххаан сумын эрүүл мэндийн төвийн 17 ортой шинэ барилгын тендерт Хөх хайрхан ХХК шалгаран Барилга угсралтын ажлыг 2021 оноос хийж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 92 хувьд хүрсэн боловч үнийн өсөлттэй холбоотойгоор ажлыг зогсоосон. Анх тендерт шалгарах үеийн төсвөөс нэмэгдсэн. 2023 оны улсын төсөвт үнийн өөрчлөлттэй холбоотойгоор 540,0 сая төгрөг батлагдсан.	90
9.1.2	Арга хэмжээ 2: Энхжин өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын угсралтын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад хүлээн авах	1,0 тэр бум төгрөг	Гүйцэтгэлийн хувь	0	Бүрэн ашигла лтад орсон байна.	Орон нутгийн төсвийн 1,6 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баруун-Урт сумын Энхжин өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын тендерт Ай Ти Си ХХК шалгаран Барилга угсралтын ажлыг 2021 оноос хийж байна. Барилга угсралтын ажлын явц 95 хувьтай үргэлжилж байна.	90
9.1.3	Арга хэмжээ 3: Онгон сумын эрүүл мэндийн төвийн барилгын засварын зураг төсвийг хийлгэх		Зураг төсвийг хийлгэсэн байна.	0	Зураг төсөв хийгдэ ж дуус-сан байна	Онгон сумын эрүүл мэндийн төвийн больницын барилгын 540,0 сая төгрөгийн өртөгтэй их засварын зураг төсвийг Зураг төсвийн Голомт Өргөө ХХК-д захиалга өгч хийлгэсэн.	100
9.1.4	Арга хэмжээ 4: Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын зураг төсвийг хийлгэх		Зураг төсвийг хийлгэсэн байна.	0	Зураг төсөв хийг-дэж дуус-	Зураг төсвийг хийлгэх захиалгыг Зураг төсвийн Голомт Өргөө ХХК-д өгсөн. Зураг төсөв хийгдэж байна. Газрын асуудал шийдвэрлэгдээгүй.	70

					сан байна		
9.1.5	Арга хэмжээ 5: Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын угсралтын ажлыг эхлүүлэх	200,0 сая төгрөг	хувь	0	20	2022 оны орон нутгийн төсвийн орлого тасарч байгаатай холбоотойгоор АЗД хойшлуулсан тул хасах	0
9.1.6	Арга хэмжээ 6: Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилгын засварын ажлыг эхлүүлэн ашиглалтад хүлээн авах	207,0 сая төгрөг	Гүйцэтгэлээр	0	Их засвар хийг- дэж дуус- сан байна.	Орон нутгийн 207 сая төгрөгийн санхүүжилтээр Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн Больницын барилгын их засварын ажлын тендерт Ёст бэйс ХХК шалгарсан. Ёст Бэйс ХХК нь их засварын ажлыг бүрэн хийж 2022 оны 10-р сард ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100
Зорилго 10: МУЗГ-ЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2.1.4.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАНА, 2.1.4.4.ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН МАШИНЫ ПАРК ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ЗЭРЭГ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1: Эрүүл мэндийн салбарт шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх							
10.1. 1	Арга хэмжээ 1: Аймгийн нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн үйлдвэр байгуулах		Бодит тоо	0	1	Улсын төсвийн 546,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулагдсан. Уг үйлдвэр байгуулагдахаас өмнө АНЭ, сумдын эрүүл мэндийн төвүүд Улаанбаатар хот болон Багануур дүүргээс хүчилтөрөгчийг тээвэрлэж байсан. Хүчилтөрөгчийн үйлдвэртэй болсноор сум, өрх, хувийн эмнэлгүүд АНЭ-тэй гэрээ гэрээ байгуулан хүчилтөрөгчийн баллоныг цэнэглүүлж байна.	100
10.1. 2	Арга хэмжээ 2: АНЭ-ийг хэвлийн дурангийн мэс заслын аппаратаар хангах	450,0 сая төгрөг	Бодит тоо	0	1	Улсын төсвийн 296,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвлийн хөндийн дурангийн мэс заслын аппарат нийлүүлэгдэж цесний бүхий л төрлийн хагалгаа, мухар олгойн хагалгаа, өрцний ивэрхий, ивэрхий нөхөх, болон эмэгтэйчүүдийн хагалгаа хийх бүрэн боломжтой болсон. 2022 оны байдлаар чулуутай цесний хүүдий	100

						авах 23 хагалгааг амжилттай хийгээд байна.	
10.1. 3	Арга хэмжээ 3: АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийг шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангах	30,0 сая төгрөг	Хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөв	0	30,0 сая төгрөг	Аймгийн нэгдсэн эмнэлэгт урологийн дурангийн хагалгааг шинээр нэвтрүүлж шээсний сүвийн нарийсал зүсэх хагалгаа-3, стент гуурс тавих хагалгаа 3, түрүү булчирхай дурангийн мэс засах хагалгаа 13 хүнд хийгээд байна. Энэ онд АНЭ, УАУ-ны эмнэлэг, ӨСЭМТ-үүдэд 3.3 тэрбум төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг олгож, хангалтыг нэмэгдүүлэн ажилласан.	100
Зорилт 2: Эрүүл мэндийн салбарт шаардлагатай түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийх							
10.2. 1	Арга хэмжээ 1: АНЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн автомашины парк шинэчлэлтийг хийх	750,0 сая төгрөг	Автомашинаар хангагдсан байгууллагын тоо	0	6	2022 онд Улсын төсвийн 31,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Уулбаян сумын ЭМТ-д Уаз Пургон автомашин, Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Түмэнцогт, Эрдэнэцагаан сумдын ЭМТ-д, АНЭ-т туулах чадвар сайтай Ланд-76 маркийн автомашин, АНЭ-т 135,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ланд-78 маркийн автомашинуудын парк шинэчлэлт хийгдсэн. Орон нутгийн төсвийн 115,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн нэгдсэн эмнэлэгт Хайсей, Приус-30 маркийн 2 автомашин, Дарьганга, Уулбаян сумдын ЭМТ Приус-30 автомашинууд, иргэдийн 44,0 сая төгрөгийн хандиваар Халзан, Түвшинширээ сумдын ЭМТ приус-20 маркийн автомашинуудын парк шинэчлэлт хийгдсэн. Нийт 14 автомашины парк шинэчлэлт хийгдсэн.	100
Зорилго 11: Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 406 дугаар тушаалыг хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл							
Зорилт 1: Эрүүл мэндийн салбарын ажилчдын ёс зүйн чиглэлээр							
11.1.	Арга хэмжээ 1: ЭМХТ-тэй		15	0	15	Эрүүл мэндийн яамны дэргэдэх ёс зүйн салбар	100

1	хамтран Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/19 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” багц цагийн сургалтад хамруулах					хорооноос Гамшгийн үеийн сэтгэл зүйн сургалтыг эрүүл мэндийн салбарын 372 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2 багц цагийн сургалт зохион байгуулсан. Хүний эрхийн аймаг дахь төлөөлөгчтэй хамтран хүний эрх, хөдөлмөрлөх эрхийн цаашид анхаарах асуудлын талаах 1 өдрийн 1 багц цаг сургалтыг 200 албан хаагчдад хүргэсэн. Нийт ёс зүйн багц сургалтыг зохион байгуулсан. Эмч, сувилагч нар 100 хувь ёс зүйн багц цагаа бүрдүүлсэн.	
11.1.2	Арга хэмжээ 2: ЭМХТ-тай хамтран Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороо, сум, өрхийн ЭМТ-ийн ёс зүйн багуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах		15	0	15	Эрүүл мэндийн газрын албан хаагчийг ёс зүй харилцаа хандлага, зөрчил дутагдлыг шийдвэрлэх ЁС зүйн зөвлөлийг байгуулан, журмыг нь батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумдын ёс зүйн багийн гишүүдийг чадавхжуулах эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Хүний эрхийн комисстой хамтарсан сургалтад ёс зүйн багийн гишүүдийг хамруулах тал дээр анхааран ажилласан. Мөн ажил хөдөлмөрөө эрхлэхэд, байгууллага албан хаагчаас гарч байгаа нийтлэг алдаа дутагдлын талаарх шалтгаан нөхцөлийг ярилцаж шийдвэрлүүлэх асуудлын талаар нээлттэй үр дүнтэй сургалт зохион байгуулагдсан. Сургалтад сум бүрээс 2 албан хаагчийг хамруулсан.	100
Зорилт 2: Хууль эрх зүйн чиглэлээр							
11.2.1	Арга хэмжээ 1: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган ажиллах		2	0	2	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан салбар нэгжүүдэд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө тусган үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар чиглэл өгч ажилласан. Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд тушаал шийдвэрт ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө зөвлөмжийг хүргүүлж ажилласан. covid-19-тай холбоотой иргэд, аан-ээс ирсэн хандив тусламжийг захиран зарцуулах, бүртгэх талаар харьяа	100

						эрүүл мэндийн байгууллагад албан тоот, цахимаар хууль тогтоомжийн талаар 6 удаа мэдээлэл хийсэн. Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах эрх бүхий албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд тайлагнасан. Шинээр томилогдсон удирдах албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийн АТГазарт хянуулж, албан тушаалд нь томилон хуулийн хугацаанд нь хөрөнгө орлогын мэдүүлгийг тайлагнасан. Шинээр Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нээгдэж байгаатай холбоотой албан байгууллагын ажилчид нь Авлигын хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх хуулийн талаар мэдээлэл хийж Байгууллагын дарга, нягтлан бодогч 2 хөрөнгө орлогын мэдүүлгийн хууль журмын дагуу гаргаж байна.	
Зорилт 3: Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох							
11.3. 1	Арга хэмжээ 1: Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх авсан аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт үнэлгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх		Хяналт үнэлгээ хийсэн байгууллагын тоо Арга зүйн зөвлөгөө өгсөн байгууллагын тоо	0	8	2022 онд Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс нь 7 удаа хуралдаж 11 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунган, шинээр 3 байгууллагад зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрөл хүссэн 9 төслийг хүлээн авч ажилласан. Тусгай зөвшөөрөл хүссэн байгууллага, комиссын гишүүдийг хууль, тогтоол шийдвэрийн талаар мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.	100
11.3. 2	Арга хэмжээ 2: Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах комиссын хурлыг улиралд 1-2 удаа зохион байгуулж, ээлжит бус		24	0	24	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 7 удаа хуралдаж 11 байгууллагын эрхийг сунган, 3 байгууллага шинээр үйл ажиллагаа явуулах эрх авсан. Шинээр үйл ажиллагаа явуулах 9 төсөл хүлээн авсан.	100

	хуралдааныг зарлах						
Зорилго 12: МУЗГ-ЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2.1.9.ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙЖ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЖ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ДЭМЖИНЭ.							
Зорилт 1: Хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт, төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийг бэлтгэх, сургах							
12.1.1	Арга хэмжээ 1: Төгсөлтийн дараах төрийн сангийн сургалтад хамрагдах эмч эмнэлгийн мэргэжилтний сургалтын төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг хангах		Сургалтын төлөвлөгөө	31	Гүйцэт гэлээр	Төгсөлтийн дараах төрийн сангийн сургалтын захиалгыг эрүүл мэндийн байгууллагуудаас авч, Эрүүл мэндийн сайд, ЭМХТ-ийн захирлын тушаалаар батлагдсан хуваарийн дагуу сургалтад хамруулж, Арьс судлал, Дотрын анагаах судлал, Мэдээгүйжүүлэг судлал, Халдварт өвчин судлал-3, Хүүхэд судлал-2 Эх барих эмэгтэйчүүд судлал-2 үндсэн мэргэшлийн чиглэлээр нийт 10 эмч, Үе бүтээх, солих мэс засал судлал, Нярай, перинатал судлал, Бүдүүн, шулуун гэдэсний мэс засал судлал, Хавдрын хими эмчилгээ судлал, Сэтгэл засал судлал, Эсийн эмгэг судлал зэрэг 6 чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалтад тус тус бэлтгэгдэж ажлын байрандаа ирж ажилласан.	100
12.1.2	Арга хэмжээ 2: Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эх барих, хүүхэд, яаралтай тусламжийн чиглэлээр АНЭ-т ажлын байрны сургалтад хамруулах		Ажлын байрны сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	0	12	Сумын эрүүл мэндийн төвийн 10 эх баригчийг ЭМГ болон АНЭ-ийн төрөх тасагт, эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетад онол практик хосолсон 7 хоногийн ажлын байрны сургалтад хамруулсан. Улсын Гуравдугаар Төв эмнэлэгт “Сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдал ” сэдэвт үндэсний VIII сургалтад АНЭ болон Сум, Өрхийн 12 сувилагч нарыг хамруулж, Амь тэнссэн үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдал, Мэс засал, мэдээгүйжүүлгийн үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдал, Дотор мэдрэлийн өвчний үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдал зэрэг дадлага сургалтад хамруулж туршлага судлуулсан. Хүүхэд нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлээр ажлын байрны дадлага сургалтыг зохион байгуулж сумын эрүүл мэндийн төвийн 8 сувилагчийг хамруулж онол, дадлага хосолсон сургалтыг зохион	100

						байгуулж сувилагч нарыг мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлсэн.	
11.1.3	Арга хэмжээ 3: Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгуулах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж тогтмолжуулах		Зөвшөөрөл сунгагдсан ажилтны тоо	63	Гүйцэт гэлээр	Эмч эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн сунгалт, мэргэжлийн зэргийн болон зөвшөөрлийн шалгалт 2022 оны 03 дугаар сараас эхлэн цахим шилжилт хийгдсэн. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд ажиллаж буй эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд ЭМХТ-ийн Хүний нөөцийн нэгдсэн системийн бүртгэлийн hr.hdc.gov.mn цахим программын танилцуулгыг ажлын байранд нь хийж, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цахимаар 100% сунгах болсноор эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажлын байрнаас цахимаар мэдээллээ илгээж эдийн засгийн хувьд үргүй зардал багассан.	100
11.1.4	Арга хэмжээ 4: Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэрэгт хамгаалах үйл ажиллагааг хангуулах, зэрэгтэй ажилтны тоог нэмэгдүүлэх		Зэрэгтэй ажилтны тоо	23	Гүйцэт гэлээр	"Төрийн жинхэнэ албан хаагчийн Дэс түшмэлийн сургалтад 1, Ахлах түшмэлийн сургалтад 3 мэргэжилтэн хамрагдсан. 16 сувилагч тусгай мэргэжилтнүүдийг зэргийн шалгалтад бэлтгэж зэрэгтэй сувилагч тусгай мэргэжилтний тоог 13-аар /Тэргүүлэх – 4, Ахлах -9 / нэмэгдүүлсэн.	100
Зорилт 2: ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР							
11.2.1	Арга хэмжээ 1: “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах, тайлагнах		Төлөвлөгөө боловсруулсан байх Тайлангийн тоо	1 2	1 2	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах 33 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн ажилтны урамшуулалд 603,3 сая төгрөг, нэмэгдэлд 1763,0 сая төгрөг, нэг удаагийн буцалтгүй тусламжид 18,3 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Коронавируст халдвар ковид-19-ын нөхцөл байдалтай холбогдуулан эрүүл мэндийн ажилтнуудад 180,8 сая төгрөгийн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл олгосон байна.	90
Нийт үнэлгээ:94%							

№	Нийт заалт	100	90	70	30	Хэрэгжих боломжгүй
---	------------	-----	----	----	----	--------------------

1	71	44	18	8	-	1
---	----	----	----	---	---	---

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХШҮДАХМЭРГЭЖИЛТЭН

ХЯНАСАН: ЭМГ-ЫН ДАРГА

Д.САРАНЗАЯА

Б.ЭРДЭНЭТУЯА